НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7799 0101
Цахим шуудан: ubhd@emg.ub.gov.mn
Цахим хуудас: www.ubhealth.mn

ДУКАТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
С.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2025.05.28 № 10-13-02/021/1276

Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

Тус газарт ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 4.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын баталсан Барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт шалгалт хийх тухай 10-00/01 дугаартай удирдамжийг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 59 дүгээр сургуулийн барилгын ажлын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат

Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан МЗХ2024/00-0261 дугаар бүхий архитектор төлөвлөлтийн даалгавартай, 2023-04 дугаартай зургийн даалгавартай. Батлагдсан загвар зурагтай.

Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээцийн ажлын зургийг Дукат ХХК-д 2025 онд боловсруулсан. ЕТ, БА- зургийн шифр DC-24A3-56.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар тус дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт боловсролын байгууллагын зориулалтаар 12004 м.кв газрыг олгосон Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 0000277932 дугаартай гэрчилгээтэй.

Барилгын давхрын байгуулалт:

Тус сургуулийн барилга нь А,Б,В,С,D, Е гэсэн 6 блоктой, зоорьтой 3 цутгамал төмөр бетонон карказ бүтээцтэй. Гадна эдэлбэр газарт явган зам, автозогсоол, хөлбөмбөг, сагсан бөмбөгийн талбай зэргийг төлөвлөсөн байна.

C:\Users\DELL\Desktop\Nergui-\dugneltuud\ДУКАТ ХХК.docx

1525140218

Нэгдүгээр давхарт гонх, үүдний хэсэг, өлгүүр, шатны хонгил, лифт, коридор, бага ангийн 54.44-54.82 м.кв талбайтай 3 хичээлийн танхим, бага ангийн унтлагын, тоглох өрөө, гадагш хаалгатай, ариун цэврийн өрөөтэй 14.72 м.кв тусгаарлах өрөө, 20.04 м.кв эмчийн өрөө, 5 албан өрөө, эрэгтэй, эмэгтэй хувцас солих өрөө, багшийн өрөө, тоног төхөөрөмжийн өрөө бүхий 712.37 м.кв спорт заал, гаднаас орох хаалгатай, бүтээгдэхүүн хүлээн авах хэсэг, 6.8-8.04 м.кв хүнсний 4 агуулах, 47.13 м.кв бэлтгэл, халуун боловсруулалтын өрөө, 16.95 м.кв хоол түгээх хэсэг,24.13 м.кв угаалгын хэсэг, ажилчдын хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, гар уаах өрөө, хооллох заалтай гал тогоо, 6 настны болон эрэгтэй, эмэгтэй сурагчдийн ариун цэврийн өрөө, багш ажилчид, ХБИ-ний ариун цэврийн өрөө төлөвлөсөн;

2 дугаар давхарт шатны хонгил, коридор, лифт, рекреаци, бага, дунд ангийн 5 хичээлийн танхим, 73.14 м.кв дүрслэх урлагийн танхим, 17.58 м.кв туслах өрөөтэй 54.88 м.кв биологийн кабинет, эмэгтэй технологийн кабинет, 3 албан өрөө, эрэгтэй, эмэгтэй хувцас солих өрөө, 2 туслах өрөө бүхий 345.43 м.кв урлаг заал, үйлчлэгчийн өрөө, эрэгтэй, эмэгтэй сурагчдийн ариун цэврийн өрөө, багш ажилчид, ХБИ-ний ариун цэврийн өрөө байхаар төлөвлөсөн;

3 дугаар давхарт шатны хонгил, коридор, лифт, рекреаци ахлах ангийн 4 хичээлийн танхим, заах аргын өрөө, 17.65-18.22 м.кв туслах өрөөтэй 54.28-54.91 м.кв талбайтай газар зүй, химии, физикийн кабинет, мэдээлэл зүй, дуу хөгжим, зургийн кабинет, 2 сан хөмрөгийн өрөөтэй 117.27 м.кв уншлагын танхим, агаар сэлгэлтийн техникийн өрөө, проекторын өрөө, гэрэлтүүлгийн тавцан, эрэгтэй, эмэгтэй сурагчдын болон хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын ариун цэврийн өрөө төлөвлөсөн байна.

<u>Барилгын халаалт, агаар сэлгэлт</u>:

Сургуулийн ангиуд, бие засах газар агаар сорох ердийн агааржуулалттай, хурлын заал, хооллох танхим, номын сангийн уншлагын заал, гал тогооны халуун боловсруулалтын өрөөнд цэвэр агаар оруулах, бохир агаар сорох механик төхөөрөмжтэй байхаар төлөвлөсөн байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн B-U2025/166 дугаартай техникийн нөхцөлтэй. УБЦТС ТӨХК-ийн 2024 оны 01/00299/24 дугаартай техникийн нөхцөлтэй.

Ундны усны хангамжийн эх үүсвэр барилгын зүүн хойно 25м зайд байрлах гүний худаг, хэрэглээнээс гарсан бохир усыг 50 м.куб багтаамжтай цооногт цуглуулан зөөвөрлөн зайлуулахаар төлөвлөсөн. Барнаб ХХК-д 2024 онд хийсэн инженер геологийн судалгаагаар дунд зэргийн нөхцөлтэй. ЗТ11-135/22

Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн ДҮГНЭХ НЬ: Барилгын зураг төслийн Дукат ХХК-ийн боловсруулсан Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 59

дүгээр сургуулийн барилгын ажлын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийхэд Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт БНбД 31-25-22 норм ба дүрмийн эрүүл ахуйн холбогдох шаардлагад нийцэж байна.

Улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үндэслэн гомдол гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ М.НЭРГҮЙ

ХҮЛЭЭН АВСАН.
ЗАХИРАЛ С.АЛТАНЦЭЦЭГ

Дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол тайлбар тэмдэглэл .....

Улсын байцаагчийн тэмдэглэл.....